

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН 2024 ОНЫ ГЭРЭЭНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2024 оны 11 сарын 30 өдөр

Мандалговь хот

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт				Хувь
		Зарцуулсан хөрөнгө сая.төг	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар /	
1	2	3	4	5	6	7
1	Удирдах, удирдуулах зарчимд суурилсан иргэдэд ээлтэй, ил тод нээлттэй, авлигагүй шударга, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлж, хүнд суртлыг арилгах арга хэмжээ авч ажиллах	0,5	Зохион байгуулсан арга хэжээний тоо	2	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргатай, Дундговь аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарын хооронд 2024 онд байгуулсан хамтран ажиллах гэрээ болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө-Манлайллын зорилтын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгайлан заалтыг тусгаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, нийтийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус байгууллагад ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна. Байгууллагын ёс зүйн зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.	100

				<p>Авлигаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн 4 зорилт 14 заалт бүхийн төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.</p> <p>Удирдлагын академаас зохион байгуулж буй төрийн албан хаагч нарт зориулсан 36 цагийн 3 түвшиний цахим сургалтад нийт 13 албан хаагч "Авлигаас ангид төрийн алба-2, Ёс зүй-6, Хүний эрх-3, Монгол бичгийн сургалтад-1, Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ-1 тус тус хамрагдаж сертификатаа авсан. Тус байгууллагын ХАСХОМ мэдүүлэх 7 албан хаагч хуулийн хугацаанд 100 хувь мэдээлсэн. Байгууллагын ил тодод нийтийн албан тушаалтнуудын хамаарал бүхий 18 этгээдийн ажил эрхлэлтийн 2024 оны судалгааг шинэчлэн гаргаж байршуулсан</p> <p>Өлзийт Говь-Угтаал, Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай сумдын малчдын зөвлөгөөн болон Хулд сумын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр байгууллагын үйл ажиллагааг сурталчилах ажлыг зохион байгуулж нийт 950 малчид, иргэдэд мэдээлэл хийсэн. Нийт 1055 ном, гарын авлага, 15 постер, шторкийг хүргэсэн.</p> <p>"Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам" болон ХХААХҮ-ийн Сайдын 2024 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан хөнгөлөлттэй зээл олгох Ерөнхий нөхцөл батлах тухай , чиглэлийн дагуу жижиг, дунд</p>	
--	--	--	--	--	--

				<p>үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн төслийг хүлээн авах үйл ажиллагааг 01 дугаар сарын 24-ний өдрийн 08:30 цагаас 02 дугаар сарын 23-ны өдрийн 08:30 цаг хүртэл Төсөл хүлээн авах цахим системээр хүлээн авсан. Төслийн зарыг олон нийтэд цахим хэлбэрээр болон биечлэн хүргэж ажилласан.</p> <p>Төсөл хүлээн авах цахим системд Дундговь аймагт хэрэгжүүлэхээр нийт 31 аж ахуйн нэгж 4,646,732,794 төгрөгийн зээлийн хүсэлтээ баталгаажсан.</p> <p>Ирүүлсэн төслүүдэд журмын дагуу дөрвөн шатны үнэлгээ хийж, 12 аж ахуйн нэгж байгууллагын 1,570,000,000 төгрөгийн зээл хүссэн төсөл тэнцсэн бөгөөд аймгийн Засаг даргын 2023 оны А/322 дугаар захирамжаар батлагдсан дэд хороо шалгарсан 12 төслийг хэлэлцэж, эрэмбэлэн Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлсний дагуу 13 ААН 1,8 тэрбум төгрөгийн зээлд хамрагдсанаар шинэ ажлын байр-31, хадгалагдсан ажлын байр-39 бий болсон.</p> <p>Дэмжигдсэн төслүүдийг салбараар нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"><li>- Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 4</li><li>- Сүлжмэл бүтээгдэхүүн 1</li><li>- Малын тэжээл гумины бордоо 1</li><li>- Модон хувин үйлдвэрлэл 1</li><li>- Хүүхдийн хувцас үйлдвэрлэл 1</li><li>- Хүнсний ногооны зоорь 1</li></ul>	
--	--	--	--	--	--

					<ul style="list-style-type: none"> <li>- Эрчимжсэн мал аж ахуй 1</li> <li>- Ахуй үйлчилгээний төв 1</li> <li>- Тавилга үйлдвэрлэл 1</li> <li>- Талх, нарийн боов үйлдвэрлэл 1</li> </ul>	
2	“Нээлттэй-Дундговь” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	2,0	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	<p>“Нээлттэй-Дундговь” хөтөлбөрийн хүрээнд шинээр үүссэн домэйн хаяг дээр байгууллагын танилцуулга, түүхэн товчоо, алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилго зорилт мөн санхүүгийн ил тод нээлттэй байдал, цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл, судалгаа шинжилгээ, бодлогын баримт бичгийн төлөвлөгөө болон тайланг тус тус баяжуулж оруулсан. Байгууллагын ил тод домэйн хаяг / <a href="https://du.hhaag.gov.mn/mn">https://du.hhaag.gov.mn/mn</a> /Байгууллагын facebook page цахим хуудсанд салбарын болоод цаг үеийн холбогдолтой бүх мэдээ мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. facebook пэйж хуудсанд нийт 87 мэдээ, мэдээллийг, аймаг орны болон байгууллагын талаарх 312 мэдээг өөрийн цахим хуудсандаа түгээж /шэйр хийсэн/ байна. Байгууллагын пэйж фэйсбүүк <a href="https://www.facebook.com/profile.php?id=100076045924978">https://www.facebook.com/profile.php?id=100076045924978</a> хуудас нь 888 дагагчтай ба иргэдэд мэдээ, мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.</p> <p>Өлзийт, Говь-Угтаал, Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай сумдын малчдын зөвлөгөөн болон Хулд сумын нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр байгууллагын үйл ажиллагааг</p>	100

					сурталчилах ажлыг зохион байгуулж нийт 950 малчид, иргэдэд мэдээлэл хийсэн. Нийт 1055 ном, гарын авлага,15 постер, шторкийг хүргэсэн. Шинэ хоршоо хөдөлгөөн, ХХСан, ЖДҮХсан, Тэжээлийн ургамал тариалах, “Хүнсний аюулгүй байдал-3 сарын аян” ны хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөгийг /75 иргэн/ зохион байгуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулалтын 9 арга хэмжээнд нийт 1025 малчид, иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан.	
3	“Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын чиглэлээр төлөвлөгөө боловсруулж үр дүнг тооцон ажиллах	0,1	Төлөвлөгөө ний хэрэгжилтийн хувь	90	Зорилтот жилийн хүрээнд 5 зорилт 9 арга хэмжээг төлөвлөн Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг 100% ханган ажилласан. Зорилтот жилийн хүрээнд тус байгууллагад хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тайланг гаргаж холбогдох хугацаанд Нийгмийн бодлогын хэлтэст хагас бүтэн жилээр хүргэн ажилласан. Онцолж хийсэн ажлаас: Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор албан хаагчид болон хүүхдүүдэд уртын дууны хичээлийг мэргэжилтэн уртын дууч Р.Галбадрах сард нэг удаа зохион байгуулж, сургалтад 5 хүүхэд, 8-н албан хаагч хамрагдаж байна. “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлж 12 ажилчдын 18 хүүхдүүдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, зохих эмчилгээг хийлгэсэн. Мөн байгууллагын нийт албан хаагчдад мэргэжилтэн Р.Галбадрах “Архи үгүй амьдрал-Аз жаргал” сэдэвт сургалтыг зохион байгуулж сурталчилсан. Энэ үеэр мөн	100

					аймгийн “Говийн хийморь” бүлэг, <b>АА</b> төвийн үйл ажиллагаа зохион байгуулалтын талаар сурталчилгаа танилцуулга хийсэн.	
4	Хүүхэд хамгааллын хүрээнд болзошгүй эрсдэлээс хамгаалсан аюулыг илрүүлэх, арилгах талаар санал санаачилга гарган ажиллах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	Хүүхэд хамгаалал, болзошгүй эрсдэлээс хамгаалах, аюулыг илрүүлэх, арилгах ажлын хүрээнд ХХААГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг сургуулийн орчны 3 худалдааны газар, нарийн боов, сүү, бууз, баншны 3 цехийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 2 худалдааны газраас хадгалалтын хугацаа дууссан 149 ширхэг бохь, 9 ширхэг шоколад илэрснийг тухайн газар дээр нь устгуулж, 2 төрлийн хаяг, шошгын зөрчилтэй бүтээгдэхүүнийг лангуун дээрээс татан авахуулсан. Стандартын шаардлага хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулсан нарийн боовны 1 цехийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож ажилласан. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнээр зөвлөмж бэлтгэж, байгууллагын вэйб сайтад байршуулж, иргэдэд хүргэн ажилласан байна. Ерөнхий боловсролын сургуулийн 3-5 дугаар ангийн 87 сурагчдад “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн”, “Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгыг хэрхэн унших”, “Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах сахар, давс, өөх тосны агууламж, Хүний өдөрт авах илчлэг, сахар, давс, өөх тосны хэмжээ”, Худалдааны газруудын хүнсний	100

					бүтээгдэхүүнийг хадгалах горимын талаар сургалт зохион байгуулсан.	
5	Аймгийн Засаг даргын 02 дугаар захирамжаар “Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалгыг” хэрэгжүүлж соёлыг дэлгэрүүлэх	-	Тогтмол зохион байгуулсан эсэх /Тийм-1, Үгүй-2/	1	Аймгийн Засаг даргын 2024 оны А/02 дугаар захирамжийн дагуу Монгол үндэсний бахархал болсон өв соёлоо түгээн дэлгэрүүлж, Монгол соёлын дархлааг бий болгох зорилгоор үндэсний дээл хувцсаа сар бүрийн 3 дахь долоо хоногийн Лхагва гарагт өмсөж, Төрийн үйлчилгээг үзүүлж хэвшсэн. Монгол дээл, хувцас өмсөж хэвших талаарх уриалга мэдээллийг өөрийн facebook, пэйж хуудсаараа дамжуулж мөн албан хаагчид энэ өдөр Монгол дээл хувцасаа өмсөн ирж төрийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж хэвшээд байна. Байгууллагын албан хаагчид Монгол үндэсний дээл хувцсаа сар бүрийн 3 дахь 7 хоног бүрт өмсөж, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлсэн. Зохион байгуулсан ажлын тайланг аймгийн Соёл урлагийн газарт хүргэн ажилласан.	100
6	Хог хаягдлаа ангилан ялгах, хоёрдогч түүхий эд авах цэгүүдэд нийлүүлэх	0,05	Нийлүүлсэн хогны хэмжээ /тн/	0,2 тн	Аймгийн Засаг дарга ХХААГ-ын даргатай 2024 онд байгуулсан гэрээнд тусгагдсаны дагуу байгууллагын албан хаагчид санаачилга гаргаж 1 сарын хугацаанд гэртээ болон байгуулага дээр ангилан ялгасан 210 кг хоёрдогч түүхий эдийг цуглуулж, худалдан авах цэг “Баялаг-төв” -д тушаасан. Орон нутгийн үйлдвэрлэгчээс зориулалтын ангилан ялгах хогийн савыг худалдан авч байгууллагын хашаанд байршуулан байгууллагаас гарсан хогийг ангилан ялгаж байна.	100

7	<p>“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж, арчлах, ургуулах ажлыг зохион байгуулах</p>	<p>УТ-250,0</p>	<p>Тарьж, арчилж ургуулсан модны тоо</p>	<p>Байгууллагын “Ногоон байгууламж”ийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх 4 заалт бүхий төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн "Хүнсний хангамж аюулгүй байдал"-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд улсын төсвийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрыг түшиглэн 3 га талбайд жимс, жимсгэний суулгац үржүүлгийн плантаци төв байгуулсан. Үржүүлгийн төвд улиас 175 ширхэг, хайлаас 700 ширхэг нийт 3 эгнээ 875 ширхэг хамгаалалтын ойн зурвас, 7 төрлийн жимс жимсгэнийн суулгац 1500, нийт 2375 ширхэг суулгацыг өнгөрсөн жил суулган хүлээн авч, арчилж, услаж ургуулж байна. Модны ургалт 50 хувьтай.</p> <p>2. Энэ жилийн хаврын “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу албан хаагчид байгууллагын хуваарьт газарт нарс, гүйлс, агч, голт бор, улиас, хайлаас, далан хальс зэрэг 8 төрлийн 14 ширхэг модыг тогоолж, шинээр тариалж Долоо хоног бүрийн Даваа, Мягмар гарагт усалж, арчлан хамгаалж ургуулсан ургалт 95 хувьтай.</p> <p>3. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас 2024 онд зарлагдсан тендерийн</p>	<p>100</p>
---	---	-----------------	--	---	------------



					<p>дагуу “Их Хайрханы хаялага” компани гүйцэтгэгчээр шалгарч, нийт 40 га талбайд агро ойжуулалтын ажлыг хийлээ. Аймгийн төвөөс 5 км зайд улсын чанартай авто зам дагуу 9-12 эгнээ хамгаалалтын зурваст улиас, хайлаас, шар хуайс, бургас мод 19000 ширхгийг, гол талбайд жимсний плантацид чацаргана, тэхийг шээг, голт бор, өрөл, гүйлс, монос, далан хальс зэрэг мод 8000 нийт 27000 ширхэг мод тарьсан байна.</p>	
--	--	--	--	--	--	--

8	“Цахим байгууллага” аяны хэрэгжилтийг хангаж ажиллах	2,0	Аяны төлөвлөгөөний хэрэгжилт	90	<p>Байгууллагын ил тод, facebook page цахим хуудсанд салбарын болоод цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Байгууллагын ил тод домэйн хаяг / <a href="https://du.hhaag.gov.mn/mn">https://du.hhaag.gov.mn/mn</a> нийт 87 мэдээ, мэдээллийг, мөн facebook пэйж хуудсанд аймаг орны болон байгууллагын талаарх 312 мэдээг өөрийн цахим хуудсандаа түгээж /шэйр хийсэн/ байна. Байгууллагын пэйж фэйсбүүк <a href="https://www.facebook.com/profile.php?id=100076045924978">https://www.facebook.com/profile.php?id=100076045924978</a> хуудас нь 888 дагагчтай ба иргэдэд мэдээ, мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.</p> <p>“Цахим байгууллага” аяны хүрээнд удирдамжийн дагуу 9 9 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.</p> <p>Байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны дундын системд бүрэн холбогдсон. Албан хаагчид албан бичиг солилцооны ERP дундын системийг бүрэн ашиглаж байгаа ба ирсэн явсан бичиг, өргөдөл гомдол мөн үүрэг даалгаварын хэрэгжилт, цаг бүртгэл зэрэг 100 хувь цахимжсан.</p> <p>Газрын даргын тоон гарын үсгээр 47 бичгийг холбогдох газруудад хүргүүлсэн. Нийтэлсэн 87-н мэдээний бүрэн бүтэн байдлыг 100 хувь хангасан.</p>	100
---	--	-----	------------------------------	----	--	-----

					Байгууллагын ирсэн явсан бичиг бүрэн цахимжсан ба явсан бичиг-214, ирсэн бичиг-327 байна.	
--	--	--	--	--	---	--

9	Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр санхүүжүүлэгч байгууллагууд (Элчин сайдын яамд, Олон улсын байгууллагууд)-д нэг болон түүнээс дээш тооны төсөл бичиж хүргүүлэх	Төсөл хөтөлбөр-79,3	Хэрэгжүүлсэн төслийн тоо	1	ДЗМОУБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийн 79,3 сая төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэдалай сумын “Далайн шим” малчдын бүлэгт 50 морьны хүчтэй трактор, дагалдах хэрэгсэл болох анжис, хөрс сийрүүлэгч, үрлэгч, хаман боогч, цахилгаан хадуур, усалгааны систем, ногоон тэжээл тариалах үр зэргийг хуваарилан олгож 5 га талбайд тэжээлийн ургамал тариалж 5тонн ургац хураан авч үр дүнтэй ажилласан..	100
10	“Дундговιο ногооруулья” хөтөлбөрийн хүрээнд байгууллага бүр хүлэмжийн ногоо тариалах, сургалтад албан хаагчдыг хамруулах	2,5 сая.т	Хамрагдсан албан хаагчдын тоо	21	Дундговιο ногооруулья” дэд хөтөлбөрийн хүрээнд хүлэмж, жимс, жимсгэний мод тарьж ургуулах, газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдэд агротехнологийн сургалтыг 04 сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулж, 15 сумын 71 тариаланч, төрийн байгууллагын ногоо тарих сонирхолтой 54 албан хаагч нийт 125 иргэн хамрагдсан. Тариаланчдад талбайн үзүүлэх сургалтыг зохион байгуулж, туршлага судалсан. ХХААГ-ын агрономич нь гэрээний хэрэгжилтийн дагуу 5 байгууллагын 25 албан хаагчид хүлэмжийн тариалалт болон төмс, хүнсний ногооны тариалалтын технологи, заавар,зөвлөгөөг талбайд өгч хамтран ажиллалаа.	100
11	Төрийн байгууллага бүр албан хэргээ хос бичгээр хөтлөх ажлыг турших	0,3 сая	Туршсан эсэх Тийм/1/, Үгүй/0	10	Байгууллагын албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлын хүрээнд “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS 6395:2022 стандартын дагуу	100

					байгууллагын хэвлэмэл хуудсыг аймгийн архивын тасгаар хянуулан стандартын дагуу хэвлүүлэн ашиглаж байна. Хос бичгээр нийт 23 албан бичиг боловсруулсанаас 1. Явсан бичиг: том тоот-9 2. Жижиг тоот-12 3. Тушаал-2 тус тус стандартын дагуу үйлдэж холбогдох яам агентлаг сумдын тамгын газруудад хүргэж, хэрэгжүүлэн ажилласан.	
100 хувь хэрэгжилттэй-10 заалт						
Биелэлтийн дундаж хувь					100	

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)

Б.МӨНХЖАРГАЛ

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦСОН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА

(албан тушаал)

Ж.ШИНЭ-УЯНГА

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

				байгууллагын хэвлэмэл хуудсыг аймгийн архивын тасгаар хянуулан стандартын дагуу хэвлүүлэн ашиглаж байна. Хос бичгээр нийт 23 албан бичиг боловсруулсанаас 1. Явсан бичиг: том тоот-9 2. Жижиг тоот-12 3. Тушаал-2 тус тус стандартын дагуу үйлдэж холбогдох яам агентлаг сумдын тамгын газруудад хүргэж, хэрэгжүүлэн ажилласан.
100 хувь хэрэгжилттэй-10 заалт				
Биелэлтийн дундаж хувь			100	

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)



(гарын үсэг)

Б.МӨНХЖАРГАЛ

(гарын үсгийн тайлал)

ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦСОН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА

(албан тушаал)

(гарын үсэг)

Ж.ШИНЭ-УЯНГА

(гарын үсгийн тайлал)